



APP

Азия Пасифик Пропертиз ХК

2014 оны 04-р сарын 14-ны өдөр

№ 47

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Үл хөдлөх эд хөрөнгүүдийн худалдах үнийг батлах тухай:

ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн өнөөгийн төслүүдийн хэрэгжилтийн явц, тулгамдаж буй асуудлуудын талаарх асуудлууд гүйцэтгэх захирлын оруулсан саналыг үндэслэн ТЭМДЭГЛЭХ НЬ:

Хөдөө орон нутагт байршилтай үл хөдлөх хөрөнгүүдээс тодорхой хэмжээний ашиг олж байгаа боловч ашигт ажиллагаанд хүрэхгүй байгаа бөгөөд энэ нь нэгдүгээрт, тэдгээрийн чанар байдал муудсан, засвар хийх нь эдийн засгийн хувьд ашиггүй, мөн тухайн орон нутаг бүрт ажилтан ажиллуулах боломжгүй, хоёрт зарим үл хөдлөх хөрөнгийн байршил аймаг сумын шинэ хөгжил дэд бүтцийн хувьд өөрчлөгдөж байгаатай холбогдон нь төвийн байршлаас алслагдах хандлага гарч байгааг харгалзан худалдах үнийг гүйцэтгэх захирал бие даан тогтоох эрхгүй байгаа тул үл хөдлөх эд хөрөнгийг худалдаагүй байгааг тэмдэглээд,

Компанийн тухай хуулийн 55.2 дах заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн эзэмшил, өмчлөлд байгаа хөдөө орон нутагт байрлалтай үл хөдлөх эд хөрөнгүүдийг худалдах үнийг хавсралтаар тогтоосугай.
2. 361,500,000 төгрөгөөр худалдан авсан үл хөдлөх эд хөрөнгийг нийтдээ 780,000,000 төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээнд компанийг төлөөлж гарын үсэг зурах, үл хөдлөх эд хөрөнгүүдийн худалдан борлуулсан орлогоор Улаанбаатар хотод хэрэгжүүлэх төслийг санхүүжүүлэх эрхийг Гүйцэтгэх захирал /Д.Галбадрах/-д олгосугай.
3. Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг /Д.Галбадрах/-д даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

Ch. M. Cashell

ЛИ МАЙКЛ КАШЕЛЛ

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот



APR

Азия Пасифик Пропертиз ХК

2014 оны 04-р сарын 14-ны өдөр

№ 48

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Оазис барилгын төслийн талбайг худалдах тухай:

Компанийн тухай хуулийн 76.1.1 болон 76.1.17, 88.1, 92.1 дах заалтуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн оазис төсөл хэрэгжиж барилга баригдсан үед уг барилгын нийт 450 м² талбайг 1 автомашины зогсоолын хамт Орон сууц захиалан бариулах гэрээний дагуу нэг м² талбайг 2000 т.н /хоёр мянга/ т.н-ээр худалдахыг зөвшөөрч, уг иргэнээс талбайн нийт үнэ болох 1,636,477,600 /нэг тэрбум зургаан зуун гучин зургаан сая дөрвөн зуун далан долоон мянга зургаан зуун / төгрөгийн гэрээг хийхийг Гүйцэтгэх захирал /Д.Галбадрах/-д зөвшөөрсүгэй.
2. Дээрх хэлцэл нь их хэмжээний хэлцэл болохын хувьд ТУЗ-ийн бүх гишүүдийн 100 хувийн саналаар зөвшөөрснийг тэмдэглэсүгэй.
3. Энэхүү гэрээнд компанийг төлөөлж гэрээнд гарын үсэг зурах, цаашид байгууллагыг төлөөлж үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Галбадрах/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  МАЙКЛ КАШЕЛЛ



Утас: 94991014, 77300380 Факс: 976-77300380

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16

Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот



APP

Азия Пасифик Пропертиз ХК

2014 оны 04-р сарын 14-ны өдөр

№ 49

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн төслийг санхүүжүүлэх тухай:

ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн өнөөгийн төслүүдийн хэрэгжилтийн явц, тулгамдаж буй асуудлуудын талаарх Гүйцэтгэх захирлаас оруулсан саналыг үндэслэн ТЭМДЭГЛЭХ НЬ:

2013 оны санхүүгийн тайлангаар өнгөрсөн жилийн үйл ажиллагааны орлого зардлаа санхүүжүүлэх хэмжээнд байж чадаагүй, түүнчлэн тодорхой шалтгаан нөхцөл байдлын улмаас зөвшөөрлүүд шийдэгдээгүй байсан тул Оазис төсөл хэрэгжиж эхлээгүй, органик бордооны судалгааны төсөл туршилтын шатандаа явж байгаа зэргээс 94,4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, энэ онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн дээрх хоёр төслийг хэрэгжүүлэх анхны хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэргүй байгаа, мөн банк санхүүгийн байгууллагаас зээл авах боломжгүй зэрэг хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан “Монголиан Пропертиз” ХХК-тай гэрээ байгуулан Оазис төслийн барилгын 800,000,000 /найман зуун сая/ төгрөгийн үнэ бүхий 302 м² талбайг 3 автомашины зогсоолын хамт худалдах гэрээ хийж, үйл ажиллагаагаа санхүүжүүлэх боломж байгааг хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх шаардлагатай байна.

Компанийн санхүүгийн нөхцөл байдал Оазис төслийг эхлүүлэх боломжгүй байгааг үндэслэн тодорхой хэсгийг зах зээлийн үнээс доогуур худалдахаас өөр аргагүй байдалд хүрсэн тул “Монголиан Пропертиз” ХХК-тай гэрээ байгуулах нь компанийн хувьд ашигтай хувилбар гэдгийг тэмдэглээд, Компанийн тухай хуулийн 76.1.1 болон 76.1.17, 88.1, 92.1 дах заалтуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Оазис төсөл хэрэгжиж барилга баригдсан үед уг барилгын нийт 302 м² талбайг 3 автомашины зогсоолын хамт “Монголиан Пропертиз” ХХК-д нэг м² талбайг 2,500,000 /хоёр сая таван зуун мянга/ төгрөгөөр худалдахыг зөвшөөрч, уг компаниас талбайн нийт үнэ болох 800,000,000 /найман зуун сая/ төгрөгийг урьдчилан авахаар тохирч Орон сууц захиалагчтай хийх хөрөнгө оруулалтын гэрээ хийхийг Гүйцэтгэх захирал /Д.Галбадрах/-д зөвшөөрсүгэй.
2. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэл болохын хувьд ТУЗ-ийн хараат бус гишүүдийн 100 хувийн саналаар, их хэмжээний хэлцэл болохын хувьд ТУЗ-ийн бүх гишүүдийн саналаар зөвшөөрснийг тэмдэглэсүгэй.

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот



APP

Азиа Пасифик Пропертис ХК

3. Энэхүү гэрээнд компанийг төлөөлж гэрээнд гарын үсэг зурах, цаашид байгууллагыг төлөөлж үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Галбадрах/-д даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА *Li M. Cashell* ЛИ МАЙКЛ КАШЕЛЛ

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: www.asiapacificproperties.mn И-мэйл: info@asiapacificproperties.mn

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16

Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот